

ТЕЛЕВИЗИЙН ХӨРӨГ НЭВТРҮҮЛГИЙН УРАН ЧАДВАРЫН ЗАРИМ  
АСУУДАЛД

(Хөрөг найруулал ба хөрөг ярилцлагын жишээн дээр)

С.Бэлгүүнзаяа\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант, сэтгүүл зүйн магистр (МА)

**Түлхүүр үгс:** телевизийн хөрөг нэвтрүүлэг, хөрөг найруулал, бичлэгийн төрөл зүйл, ур хийц, агуулга ба хэлбэр, сэтгүүлчийн уран чадвар.

Сэтгүүл зүйн бичлэгийн бие даасан томоохон төрөл болох хөрөг нь анхлан тогтмол хэвлэлд нийтэлдэг бичвэрийн зүйл байсан бол өнөөдөр телевиз, радиогийн нэвтрүүлгийн төрөл зүйл болон хөгжиж, дан ганц үгээр бус дуу чимээ, дүрс зураглалаар баяжигдан үзэгчдэд хүрч байна. Хөрөг нь ингэж хөгжихдөө тодорхой хэвд баригдалгүй телевизийн бүхий л төрөл зүйлд хөрвөх чадвартай болжээ. Тухайлбал, хөрөг нийтлэл, хөрөг найруулал, хөрөг ярилцлага, кино хөрөг, хөрөг сурвалжилга, хөрөг зураглал гэх мэт. Гэвч эдгээр жанрт уусан орохдоо хөрөг нэвтрүүлгийн үндсэн чанараа алдаж саармагжсан нь олонтоо ажиглагддаг. Чухамдаа телевизийн хөрөг нэвтрүүлэг гэж бүрэн тодорхойлохуйц ур хийцтэй (форматтай) телевизийн бүтээл хуруу дарам цөөн байна. Тиймээс телевизийн хөрөг нэвтрүүлгийн төрөл зүйл (жанр), хийц (формат), өөрчлөлт шинэчлэлтийн байдал хийгээд хөрөг нэвтрүүлгийн уран чадварын зарим асуудлыг хөрөг болон хөрөг ярилцлагын нэвтрүүл-

гүүдийн жишээн дээр эмпирик түвшинд судаллаа.

Хүний дүр байдлыг дуурайлган хийсэн зураг дүрс, цутгамал, сийлмэл, баримал, зурмалыг хөрөг гэж дүрслэх урлагт тодорхойлдог. Тэгвэл сэтгүүл зүйд тэр дундаа телевизийн урлагт хөрөг нь бие хүн түүний гадна төрх, зан, араншин, хүсэл тэмүүлэл, харьцаа, орчин нөхцөлтэйгөө багтаж, хөдөлж байдгаараа ялгаатай. (Банзрагч, 2006). Телевизийн хөрөг нь энгийн чөлөөтэй үг хэл, үйл хөдлөл, зураг дүрслэл, дуу хөгжмөөр хүний дотоод ертөнц, хүсэл тэмүүлэл, зан байдал, хэний ч мэдэхгүй өвөрмөц далдхан ертөнцийг нь өөртэй нь хамжин нээн харуулдгаараа онцлогтой. Хөрөг нэвтрүүлэг бол хувь хүн, нийгмийн бодит амьдрал, цаг үеийн үйл явдал дээр үндэслэн бүтээгдэхийн хувьд түүхэн баримт болж үлддэг үнэ цэнтэй телевизийн бүтээл юм. Тиймдээ ч уран бүтээлчдээс ур чадвар, уйгагүй хөдөлмөр, мэдрэмж, мэргэжлийн ёс зүй болоод цаг хугацаа шаарддаг онцгой төрөл зүйл билээ. Харин үзэгчийн зүгээс үзвэл энэ нэвтрүүлгийн төрөл нь хөрөг найрууллын баатраар дамжуулж хүний нийгмийн сайн сайхныг тольдох, түүнээс үлгэр дуурайл авах, магадгүй алдаанаас нь суралцах, амжилтын

нууцыг нь мэдэх гээд танин мэдэхүйн болон хүмүүжлийн өндөр ач холбогдолтой басхүү сонин содон телевизийн хөтөлбөр гэж тодорхойлж болох юм. Хүмүүсийн сониуч зан улам ихэссэн өнөө цагт хөрөг нэвтрүүлэг үзэх үзэгчдийн хандалт өссөөр байна. Гагц эрэлт их байгаа энэ нэвтрүүлгийг уран чадварын өндөр түвшинд, үнэн бодитой, сонирхолтой хамгийн гол нь мэргэжлийн ёс зүйтэй бүтээх асуудал телевизийн уран бүтээлч бидэнд чухлаар тавигдаж байна.

“Телевиз өөрийнхөө асар удам болохыг тунхаглав. Урлагийн төрөл зүйлийн хоорондын зааг ялгаа арилж, төрөл зүйл, төрөл хэлбэрийн хил хязгаар үгүй болов. Энэ үйл явцыг зогсоох аргагүй” хэмээн Оросын театрын аугаа найруулагч Г.Товстоногов хэлсэн байдаг (Наранжаргал, 2006). Үнэхээр ч сэтгүүл зүйн бичлэгийн төрөл тэр дундаа телевизийн нэвтрүүлгийн төрөл зүйлийн (жанр) тухай ойлголт байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж, судлаачдын дунд маргаан үүсгэдэг. Телевизийн сэтгүүл зүйн хөгжлийн эхэн үед сонины төрөл зүйлтэй адилтган, бичлэгийн тогтвортой шинжийг эрж хайж байв. Гэтэл одоо телевизийн бичлэгийн төрөл зүйлийг тодорхойлон ангилах нь улам хүндрэлтэй болж байна. Холимог аргаар бүтээсэн төрөл бүрийн телевизийн нэвтрүүлгүүд олширч, хийцийн хувьд байнга өөрчлөгдөн, шинэчлэгдэж, нэг нэгэндээ ууссан нийллэг бүтээл олон төрөх болжээ. Хөрөг нэвтрүүлэг гэж бүрэн тодорхойлж болохгүй ч хөрөг нэвтрүүлгийн элементийг өөртөө агуулсан мэдээ сурвалжилга, цэнгээнт хөтөлбөр, ток шоу, соёл урлагийн теле сэтгүүл, хүүхэд залуучуудын танин мэдэхүйн хөтөлбөр болоод теле ярилцлагын нэвтрүүлгүүдийг бид бүхэн өргөн нэвтрүүлгийн сувгуудаар

өдөр бүр үзэх боломжтой болжээ. Хөрөг бол сэтгүүл зүйн нийлмэл төрөл юм. Түүнийг бүтээхэд ярилцлага, сурвалжилга, мэдээ гээд сэтгүүл зүйн мэдээллийн төрлийн бараг бүх элемент шаардагдана. (Батжаргал, 2008). Аливаа нийтлэл, нэвтрүүлгийн гол баатар нь ихэвчлэн хүн байдаг. Хүн бол нээж дуусашгүй ертөнц. Тиймээс ч телевизийн нэвтрүүлгүүдийн төрөл жанрт бүрт хөрөг нэвтрүүлгийн шинж чанар уусан холилдох нь зүй гэлтэй.

**Б**усдын тухай мэдэхийг хүсдэг хүмүүсийн сониуч зангийн “ачаар” хөрөг бол сэтгүүл зүйн бичлэгийн нэлээд түгээмэл төрөлд ордог (Мелвин Менчер, 2001). Үнэхээр ч телевизийн урлаг үүссэн цагаас эхлэн хөрөг нэвтрүүлэг үзэгчдийн анхаарлыг ихэд татсаар иржээ. Манай орны хувьд телевизийн хөрөг нэвтрүүлэг 1967-1968 оны хооронд цацагдаж байсан “Ард овогтой хүн”, “Төрийн шагналтан” нэвтрүүлгүүдээс эхтэй гэж үздэг. Монголын зурагт радио анх байгуулагдсан 1967 оноос эхлэн хөдөлмөрийн алдар цуутай хүмүүсийн хөрөг найрууллыг бичиг зохиолын их авьяастан Шаравын Сүрэнжав, Долгорын Пашка, Пүрэвжавын Пүрэвсүрэн нар бэлтгэж эхэлжээ. Хамгийн анхны телевизийн хөрөг нэвтрүүлэг 1967 оны 11-р сарын 25-нд цацагдсан “Ард овогтой хүн” нэртэй нэвтрүүлгийн анхны дугаар болох ардын жүжигчин Д.Ичинхорлоогийн хөрөг байлаа. Тус нэвтрүүлгийг залуу сэтгүүлч Ш.Сүрэнжав, найруулагч Л.Шийтэртэй хамтран бүтээж байжээ. Тухайн жилдээ “Ард овогтой хүн” нэвтрүүлгээр Ардын жүжигчин Д.Ичинхорлоо, О.Дашдэлэг, З.Цэндээхүү, Ц.Цэгмид, Г.Гомбосүрэн, Ж.Данзан (алиа Данзан), харин “Төрийн шагналтан” нэвтрүүлгээр яруу найрагч Ч.Лхамсүрэн, Л.Мөрдорж, Төрийн хошой шаг-

налт, Ардын жүжигчин Б.Дамдинсүрэн, зохиолч Д.Намдаг, Ч.Лодойдамба зэрэг манай урлаг соёлын нэрт хүмүүсийн амьдрал, уран бүтээлийн тухай цуврал найруулал орж байлаа. 1967-1968 оны зурагт радиогийн дэлгэцнээ гарч байсан эдгээр хөрөг найруулал одоогийнхоос юугаараа ялгаатай вэ гэвэл синхрон яриа бүхий дуутай сюжет, дүрс бичлэг байхгүй, харин фото зураг ихтэй байв. Мөн нэвтрүүлгийн баатрууд шууд л өөрсдөө эфирт ярьж байжээ.

**У**лс оронд өөрчлөн байгуулалт өрнөх үед хөрөг ярилцлагын нэвтрүүлэг шинэ агуулгаар баяжиж эхэлсэн юм. Тухайлбал, зохиолч, сэтгүүлч Д.Дождоржийн гардан хийж байсан “Түүхийн өмнө хүлээх хариуцлага” цуврал нэвтрүүлгийн анхны дугаар “Ю.Цэдэнбалын улс төрийн хөрөг”-өөр бэлтгэгдэн 1990 оны 2-р сарын 25-нд дэлгэцнээ гарчээ. Энэ цагаас хойш хөрөг ярилцлагын шинжтэй нэвтрүүлэг Үндэсний телевизийн нэвтрүүлгийн сүлжээнд өөрийн гэсэн байр сууриа эзэлж үзэгчдийн хүртээл болсоор ирсэн юм. Тухайн цаг үеийн хөрөг нэвтрүүлэг бол үлгэрлэн дуурайлах, манлайлах рольд уриалан дуудах гэсэн ерөнхий агуулгын доор хүмүүсийн ажил хөдөлмөр, амжилтыг магтан дуулсан хийцтэй байлаа. Хүний зан авир, амьдрал руу, дотоод асуудал руу нь нэг их ордоггүй байв. Чухам урлаг спортын алдартнууд гавьяатууд, социалист хөдөлмөрийн баатруудын алдар хүндийг нь магтан дуулсан, гаргасан амжилтаар нь ард түмэнд үлгэр дуурайл болгох зорилготой хөрөг нэвтрүүлгүүдийг ихээр хийдэг байв. Энэ хөрөг нэвтрүүлгүүдийн хэл найруулга, бичлэгийн ур чадвар өндөр байсныг онцлох хэрэгтэй. Учир нь радиогийн утга зохиолын редакцад ажиллаж байсан зохиолчид телевизийн хөрөг нэвтрүүлгүүд хийж

эхэлсэн явдал байв. Зохиолчид бол хүний дотоод сэтгэлгээ, оюун санааны гүн рүү нэвтэрч ордог сэтгэл судлаач мастерууд байдаг. Харин 1990 оноос хойш нөхцөл байдал өөрчлөгдөж, нийгэм солигдоход хөрөг нэвтрүүлгийн үндсэн агуулгад өөрчлөлт орж ирсэн. Одоогийн ойлголтоор хөрөг нэвтрүүлэг нь: Энэ хүн хэн бэ? ямар хүн бэ? юу хүсэж, юу бодож, юунд зовж, юунд шаналж яваа хэн гэдэг бодгаль вэ? гэдгээр нь бүрэн зураглахыг хэлнэ. Хөрөгт тухайлсан нэг хүний талаар эсвэл аль болох тодорхой сэдэв, асуудлыг дагнан өгүүлэхдээ гол баатраар дамжуулж үзэгчдэд хүргэх, түүнийхээ урт богино хугацааны түүх, дүр зураг, төрх төлөвийг нь гарган үзүүлэхийг чухалчилдаг. Иймээс хамрах хүрээ хугацааны хувьд харилцан адилгүй байх нь элбэг. Хэн нэгэн хүний бүх л амьдралын түүхийг багтаасан, эсвэл хэсэгхэн хугацаа ганц л тохиолдол үйл явдлыг харуулсан байж ч болдог. Тиймдээ ч орчин цагт хөрөг нэвтрүүлгүүдийн хэлбэр хийц, үзэгчдэд хүргэж буй арга техник нь мөн адил харилцан адилгүй байх болжээ.

Чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдсан үеэс арилжааны телевизүүд шил шилээ даран төрөхөд хөрөг болон хөрөглөсөн ярилцлагын нэвтрүүлгүүд илүү олноор гарах болсон. Хөрөг ярилцлага бол манай сэтгүүл зүйд өнгөрсөн зууны ерээд оны эхэн үеэс орж ирсэн шинэ хэлбэр бөгөөд заримдаа хөрөглөсөн ярилцлага гэж нэрлэдэг. Ярилцагчийн сэтгэлийн ертөнцийг харилцан ярианы аргаар нээн харуулахад гол зорилго нь оршино (Зулькафиль, 2018). Орчин цагийн сэтгүүл зүйд хүч түрэн орж ирсэн хөрөглөсөн ярилцлагын нэвтрүүлгүүд чухам хөрөг нэвтрүүлгийн мөн чанарт нийцсэн, агуулга хэлбэрийн зохилдлоготой, мэргэжлийн ёс зүйтэй,

үзэгч олонд үр өгөөжтэй хийгдэж байна гэвэл бас учир дутагдалтай. Монголын уламжлалт сэтгүүл зүйн үндсийг бичиг соёлын их авьяастай хүмүүс босгож, билэг авьяасаа зориулж явсан учраас нийтлэл, нэвтрүүлгийн найруулга зүй, ур чадвар өндөр байжээ. Харин өнөөдөр мэргэжлийн ур чадвар дутмаг сэтгүүлч, найруулагч мөн мэргэжлийн бус хүмүүс ч телевизийн салбарт олноор ажиллах болсон нь телевизийн нэвтрүүлгийн бичлэгийн ур чадварын хийгээд ёс зүйн асуудал болж байгаа нь үнэн.

**Е**р нь хөрөг нэвтрүүлэг бүтээхэд сонгосон баатраар дамжуулан хэлэх гэсэн санаа, нийгэмд хүргэх мессеж хамгаас чухал байдаг. Тиймээс нэвтрүүлгийн гол баатар телевизийн дэлгэцэд хэрхэн амилах нь зөвхөн уран бүтээлчдээс хамааралтай тул нарийн мэдрэмж, ур ухаан, дүрслэн илэрхийлэх чадамж, ур дүй ихээхэн хэрэгтэй. Түүнчлэн телевизийн хөрөг бүтээхэд дан ганц сэтгүүлч, редакторын ярилцлага хийх авьяас, бичлэгийн ур чадвараас гадна зургийн баг хамт олны нэгдмэл байдал, багийн ажиллагаа, ур ухаан, мэргэжлийн чадамж ихээхэн нөлөөтэй. Нөгөөтээгүүр агуулгагүй хэлбэр, хэлбэргүй агуулга орших боломжгүй гэдгийг шинжлэх ухаан онолын хувьд, нийгмийн амьдрал практикийн үүднээс баталсан байдаг. Тийм учраас сэтгүүл зүйн онолд нийтлэл, нэвтрүүлгийн аливаа төрөл агуулга хэлбэрийн нэгдэл төдийгүй сэтгүүлчийн ур чадварын шалгуур гэж үздэг. Сэтгүүлч сонгож авсан сэдвийн агуулгыг илэрхийлэхийн тулд ямар нэгэн хэлбэрийг урлан бүтээсний үндсэн дээр нийтлэл эсвэл нэвтрүүлэг төрдөг. Ийм бүтээл агуулга, хэлбэрийн үл салах нэгдлийн үр дүн болдог онцлогтой. Тэгвэл хэлбэр нь агуулгаасаа хэтийдсэн телевизийн

нэвтрүүлгүүд тэр дундаа хөрөг ярилцлагын нэвтрүүлгүүд телевизийн эфирийг өнгөлөх боллоо. Нэг хэсэг үзэгчдийг байлдан дагуулсан, өнөөдөр ч үзэлтийн рейтингээ алдаагүй байгаа “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийг энд жишээ татъя. Утга уянга, омогшил бардамналд дуртай бидний цөсийг хөөргөх, сэтгэлийг огшоох дүрс зураглал, найруулга, дуу хөгжим, шүлэг найргаар баяжмал энэ нэвтрүүлэг яах аргагүй хэн хүнийг дэлгэцийн өмнө уядаг. Хөдөлмөр бүтээлээрээ төр засаг, түмэн олондоо хүндлэгдсэн эрхмүүдтэй ярилцаж, түүхэн архив үлдээж буйг нь бодвоос “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг үнэ цэнтэй бүтээл мөнөөс мөн. Гэвч хөтлөгч, редакторын уран чадвар болоод мэргэжлийн ёс зүйн алдаа тэнд олонтоо ажиглагддаг. Хөрөглөж байгаа хүнийхээ хэт хувийн нууц руу орж, хувь хүний нууцын тухай хуулийг зөрчсөн мэдээллийг нийтэд дэлгэж зочноо ам алдуулан яриулах, эфирт зочдын хамтаар тамхилах, шалиг завхай үгс хэрэглэх, заримдаа зочныхоо халамцуу хэт сэтгэл нь хөөрсөн үед нь нууц бичлэг, ярилцлага хийж түүнийгээ сюжет болгон ашиглах нь нэн зохимжгүй. Түүнчлэн хөтлөгчид зочныхоо хоёр талд суугаад түүнийг өөд уруугүй, уянгалан магтах нь хөрөг нэвтрүүлгийн дүрийг уран нарийн бүтээх, тухайн нэвтрүүлгийн баатрын тухай сайнтай, муутай бүрэн зураглал үзэгчдэд хүрэхэд саад болдог. Ерөөс алив юмс өөртөө тохирсон донж дан, өмсгөл зүүсгэлтэй байдаг. Хурц тод хэллэг, өнгө будгийн зохицол гэж бас бий. Магтаал сайшаалыг хэтрүүлж, өнгө гэрлийг алдагдуулж болохгүй. Хэтрүүлбэл хөргийн баатраа ичээж, эвгүй байдалд оруулдаг онцлогтой. Иймээс “ихэсгэл, багасгалын тунг тохируулж, хужир давсыг нь тааруулах нь чухал

юм. Хөргийн баатрыг хар зураг гэвэл магтаал сайшаал бол будаг нь юм. Иймд будаг, шунхыг нь тааруулж чимэглэхгүй бол зохимжгүй” (Банзрагч, 2006).

**Т**эгвэл өнөө цагт мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд хийгдсэн, сэтгүүлч хөтлөгчийн уран чадвар өндөр, телевизийн хөрөг нэвтрүүлэг байгаа юу гэвэл бий. Энэ бол МҮОНТ-ийн “Гэгээн үдэш” нэвтрүүлэг билээ. Энэ нэвтрүүлгийг сэтгүүлч Ш.Ёолк /СГЗ/, Г.Золжаргал /СГЗ/ нар хөтлөн явуулдаг бөгөөд Монголын урлагийн салбарт авьяас билэг, эрдэм ухаан, хүч хөдөлмөрөө хоёргүй сэтгэлээр зориулсан сод билигт хүмүүсийн бүтээн туурвиж үлдээсэн оюуны үнэт бүтээлээр дамжуулж, тэдний туулж өнгөрүүлсэн амьдрал, уран бүтээлийн түүхийг үзэгч түмэнд дэлгэн харуулдаг. Ингэхдээ өнөөдөр бидэнтэй хамт байхгүй ч, уран бүтээлээрээ хамт оршиж байгаа тэр эрхмүүдийн тухай хүүрнэн ярьж, хөрөглөн зурж, хөшөө дурсгалыг нь телевизийн дэлгэцэд босгодгоороо онцлогтой. Нэвтрүүлгийн баг хөрөг баатрынхаа тухай бүрэн зураглал гаргахын тулд амьдрал амжилт, уналт босолт, үнэн түүхийг нь хэлэлцүүлгийн түвшинд аваачиж олон хүмүүсийн үзэл бодол, дурсамж, дуртгалаар илэрхийлдгээрээ давуу талтай. Энэ нэвтрүүлэг судалгааны материал ихтэй, ур хийц сайтай, чамбай нэвтрүүлэг гэдэг нь харагддаг. Тиймээс “Гэгээн үдэш” нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, судалгааны ажил, ашиглаж байгаа ховор нандин хроника, сэтгүүлч хөтлөгчийн уран чадварын асуудлыг “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэгтэй жишин үзвээс “Гэгээн үдэш” нэвтрүүлэг жин дарна гэдэгт салбарын мэргэжилтнүүд санал нэгдэх биз ээ.

“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг гарсан цагаас хойш ийм форматтай нэвтрүүлэг телевизүүдэд дэлгэрэх хандлагатай болж ирсэн. Тухайлбал, П.Анужингийн бэлтгэдэг “МонГал товчоон”, сэтгүүлч Л.Мөнхбаясгалангийн “Гэргий” нэвтрүүлгийн формат “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэгтэй эгээ л нэг ижил. Гэвч формат ижил ч зураглаач, найруулагчийн уран чадварын ялгаа тэнд бас харагддаг. Тухайлбал, сэтгүүлч Л.Мөнхбаясгалан өөрөө ерөнхий найруулагчаар нь ажиллаж, хөтлөн явуулдаг “Гэргий” хөрөг нэвтрүүлэг зураг авалтын хувьд хэдий сайн ч, найруулгын хувьд ур муутайг Г.Оюун /Г.Батхүү агсны ээж/ гуайн оролцсон дугаараас харж болно. Хөрөг нэвтрүүлэгт баримт, уран сайхны аргыг хослуулахдаа найруулагч нарийн мэдрэмжтэй байх шаардлагатай. Гэтэл нэвтрүүлгийн эхнээс л найруулга зүйн алдаа гарч эхэлдэг. Хичээлээ тасалсан сурагчийн араас явсан багшийн сэтгэлийг харуулахдаа хэт хүндрүүлж хүүг сургуулиаасаа оргосон болгож, харин багш нь нохойнд хазуулаад, үхлүүт гэртээ үг дуугарч ч чадахгүй хэвтэж байгаагаар зохиомжлон харуулжээ. Гэтэл оролцогчийн ярианаас зохиомжийн үйл явдал зөрдөг. Чухам хар нохойн архиралт, уйлаан, орилооноор нэвтрүүлгээ эхлүүлэх ямар учир байсан бэ гэж бас бодогдоно. Энэ шийдэл нь зүгээр л үзэгчдийн анхаарлыг айдсаар татах гэсэн ядмаг арга уу даа гэж ойлгогдохоор аж. Нохойнд уруулсан тухай эхлэл зохиомж удалгүй нутаг усны тухай яриагаар үргэлжилнэ. Нэг агуулгыг бүрэн дуусгаагүй мөртөө дараагийн агуулга руу шилжсэн, ярианы үсэрсэн эвлүүлэг энэ нэвтрүүлэгт их ажиглагдана. Мөн оролцогч өөрөө яривал илүү амьд бөгөөд сонирхолтой болох нандин

дурсамжийг олны танил яруу найрагчаар уянгалуулан уншуулах, үр хүүхдүүдээр нь эхийн тухай дууг ээлжлэн дуулуулах зэрэг хэт тавилттай, хэлбэр хөөсөн чимэглэлүүд нэвтрүүлэгт олон. Түүнчлэн хөтлөгчийн асуулт нь хөрөг баатрынхаа дотоод ертөнцийг хангалттай нээгээгүй намтарчилсан, үйл явдал хөөсөн, заримдаа өрөөл бусдын түүх рүү ч хэлбийсэн байгаа нь элбэг. “Гэргий” нэвтрүүлэг бол сэтгүүлч нь найруулгаа хийдэг редактор төвтэй төсөл юм. Тиймээс ч найруулгын хувьд учир дутагдалтай байгаа нь илхэн. Сэтгүүлч хүн хөрөг нэвтрүүлгийнхээ туйлын зорилгод хүрэхийн тулд хөргөө яаж эхлүүлэх вэ, яаж зангидах вэ, яаж өрнүүлэх вэ, дээд туйл нь юу байх вэ, энэ зөрчил тэмцэл, баримт сэлт яаж тайлагдах вэ, яаж төгсгөх вэ гэдгийг сонирхол татахуйц хэлбэрээр өрж, нэвтрүүлгийн араг ясыг босгох учиртай. Гэвч “Гэргий” нэвтрүүлэгт ийм ур чадвар дутмаг байна.

Тэгвэл найруулагч нь редакторын үүргээ хамт гүйцэтгэдэг нэг нэвтрүүлгийг бас онцолъё. Энэ бол “Түлхүүр студи”-ийн найруулагч Б.Энхнөхөрлөлийн “Миний үнэн” нэртэй хөрөг нэвтрүүлэг юм. Тус нэвтрүүлгийн анхны дугаар энэ оны 2-р сард цацагдсан бөгөөд нэвтрүүлгийн гол дүр нь театрын найруулагч Ч.Найдандорж /УГЗ/ байв. Нэвтрүүлгийн хийц их энгийн бөгөөд хар цагаан зураглалтай. “Гэргий” нэвтрүүлэг шиг зун, намар, өвлийг дамнасан урт хугацааны өнгөлөг зураг авалт энэ нэвтрүүлэгт огт байхгүй, олон объект ч солихгүй, оролцогч нь өнгө, өнгийн дээл, хувцсаар гангалахгүй. Зургийн баг нэвтрүүлгийн баатраа огт магтсангүй бас муулсангүй харин өөрийнх нь тухай өөрөөр нь үнэн түүхийг нь яриулахдаа хөрөг нэвтрүүл-

гийн зураг авалтын гол амин сүнс болох *крупный план (close-up in filmmaking)* дээр маш сайн тоглолтыг хийж чадсан нь том ололт юм.

**Х**өрөг нэвтрүүлэгт зайлшгүй тавигдах шаардлагатай зураг авалт, хэсэгчилсэн дүрс буюу план гэж бий. Хүний нүд ярихаас илүүг өгүүлж байдаг. Хөрөг баатрын дотоод ертөнцийг нээн ярилцахдаа түүний нүүр, нүдийг дэлгэцнээ томруунаар нь харуулах нь үзэгчийг тухайн хүний ертөнцөд хөтлөн оруулахад тусалдаг. Мөн аливаа хүн, объектод өөрийн өвөрмөц шинж чанар байдаг. Түүнийг тодруулахын тулд илүү нарийвчилсан том дүрс хэрэг болдог. Өгүүлэгчийн нүд, түүний энгэрт буй одон тэмдэг, ширээн дээр байгаа, эд хогшлын дүрсийг телевизийнхэн деталь гэж хэлж заншсан. Энийг томруун дүрс гэж нэрших нь бий. “Томруун дүрс бол гүн гүнзгий гэдэгтэй адил төстэй” гэж Оросын алдарт кино найруулагч В.Пудовкин хэлсэн байдаг. Хөрөг том дүрс (портретный крупны план) гэхэд хүний дотоод ертөнцөд нэвтрэх боломж олгодог. Дэлгэц дээр хүний сэтгэлийн толь гэгдэх нүдийг том дүрсээр харуулж болно. Мөн тухайн хүний хөдөлгөөн, дохио зангалт, нүүр царайны хувирлыг ажиглан, юунд баярлан юунд шаналж буйг энэ дүрсний сонголтоор илэрхийлж болдог.



Зураг 1. Томруунаас томруун дүрс (очень крупный план) мөн өөрөөр хөрөг том дүрс нэршдэг (портретный крупны план). Эх сурвалж: [http://editlw.ru/articles.php?article\\_id=42](http://editlw.ru/articles.php?article_id=42)

Тиймээс телевизийн хөрөг нэвтрүүлэг дээр томруун дүрс маш чухал. Харамсалтай нь манай зураглаачид үүнийг ашиглах нь хомс байна. Харин “Миний үнэн” нэвтрүүлэгт *очень крупный планыг (томруунаас томруун дүрслэл)* олон талаас нь авч ашигласан нь их сайшаалтай. Мөн тухайн нэвтрүүлгийн найруулагч хэр баргийн хөтлөгч, сэтгүүлчээс дутахааргүй асуултыг зочноосоо асууж, түүний зүрх сэтгэлийн чанд дахь үнэнийг уудлах гэж оролдож байгаа нь магтууштай. “Миний үнэн” нэвтрүүлэг бол цөөхөн уран бүтээлч ажилласан гэхэд гүйцэтгэл сайтай, хөрөг нэвтрүүлгийн зураг авалтын үндсэн форматыг барьж чадсан, агуулга хэлбэрийн тэнцэлд нэлээд ойртсон бүтээл болж чаджээ.

Орчин цагийн хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн гол алдаа нь агуулга хэлбэрийн тэнцлийг барьж чадахгүй байгаад оршино. Олон объектод сэлгэж авсан синхрон ихтэй, зохиомж, дуу шум чимэглэл, сюжет элбэг, шилжилт олонтой, хэмнэл сайтай эвлүүлэгтэй л бол сайн хөрөг нэвтрүүлэг гэсэн үг огтоос биш юм. Дүрийн сонголт, сэтгүүлчийн бичлэгийн уран чадвар, ярилцах ур техник, зураглаачийн торгон мэдрэмж, тухайн баатраа бүрэн зураглах чадвар, най-

руулагчийн найруулан урлах авьяас хамгийн гол нь зургийн багийн мэргэжлийн ёс зүйтэй байдал гээд их зүйл бий гэдгийг санууштай. Чухам ийм шаардлагыг хангасан хөрөг нэвтрүүлгүүд 1975-2000-аад онуудад гарч байсан юм. Тухайлбал, сэтгүүлч асан

Б.Доржийн “Гавьяа” хэмээх цуврал хөрөг найруулал телевизийн сэтгүүл зүйн түүхэнд жинтэй хувь нэмэр оруулсан билээ. 1975 онд Ардын жүжигчин Р.Чулуун агсны тухай хөрөг найрууллаар эхэлсэн энэ цувралаар урлаг, соёл, нийгмийн алдартан, жирийн малчин ажилчин зэрэг жаран хүний хөрөг найруулал бэлтгэж байжээ. Үүний дараачаар сэтгүүлч Д.Амбасэлмаа, М.Банзрагч, Ш.Сүрэнжав, Д.Дождоорж, Ш.Ёолк, Г.Золжаргал, Ш.Гүрбазар, найруулагч Д.Хишигт, Ч.Гомбо, Го.Бадарч нарын бүтээж байсан хөрөг найрууллууд телевизийн хөрөг нэвтрүүлгийн сонгодог формат

«

**Орчин цагийн хөрөг нэвтрүүлэг бүтээгчдийн гол алдаа нь агуулга хэлбэрийн тэнцлийг барьж чадахгүй байгаад оршино. Олон объектод сэлгэж авсан синхрон ихтэй, зохиомж, дуу шум чимэглэл, сюжет элбэг, шилжилт олонтой, хэмнэл сайтай эвлүүлэгтэй л бол сайн хөрөг нэвтрүүлэг гэсэн үг огтоос биш юм. Дүрийн сонголт, сэтгүүлчийн бичлэгийн уран чадвар, ярилцах ур техник, зураглаачийн торгон мэдрэмж, тухайн баатраа бүрэн зураглах чадвар, найруулагчийн найруулан урлах авьяас хамгийн гол нь зургийн багийн мэргэжлийн ёс зүйтэй байдал гээд их зүйл бий гэдгийг санууштай. Чухам ийм шаардлагыг хангасан хөрөг нэвтрүүлгүүд 1975-2000-аад онуудад гарч байсан юм**

»

байсан гэхэд болно. Тэгэхээр агуулга, хэлбэр салшгүй нэгдмэл бөгөөд агуулга нь хэлбэрийн хувьд гол зүйл боловч хэлбэрийг идэвхгүй тооцож бас болохгүй (Зулькафиль, 2018) гэдгийг алтан үеийн уран бүтээлчид сайтар мэдэж,

аливаа бүтээлдээ давс хужрыг нь тааруулдаг байсан нь телевизийн архивд үлдсэн алтан фондын нэвтрүүлгүүдээс тодхон харагдана. Тэдэнд одоогийнх шиг хүчин чадал өндөр камер, дуу шум авах техник, дүрс эффект, гэрэлтүүлгийн технологи, график эвлүүлгийн шийдэл байсангүй, гэвч тэд хүний дотоод ертөнцийг нээн харуулах, хөрөг баатрын дахин давтагдашгүй өвөрмөц онцлогийг товойлгон гаргах, түүгээр дамжуулан хүмүүнлэг нийгмийн олон талт асуудлыг хөндөж, зөвхөн нэг хүний түүхээр нийгмийг соён гэгээрүүлж чадах мэргэжлийн уран чадвартай байжээ. Тэгвэл орчин цагийн телевизийн хөрөг нэвтрүүлгийн сайн жишиг болох бүтээлүүдийг энд бас дурдах нь зүй юм. Монголын кино урлагийн нэрт төлөөлөгч, кино зохиолч, найруулагч Ч.Гомбо /СГЗ/ агсны хүү сэтгүүлч, найруулагч Г.Золжаргал /СГЗ/, мөн түүний хүү найруулагч, зураглаач З.Батбилэг /СТА/ нарын “Zoljargal&Son film” студийн бүтээлүүд өнөө цагийн хөрөг нэвтрүүлгийн сайн жишиг гэж тодорхойлж байна. Учир нь энэ үе дамжсан авьяаслаг уран бүтээлчдийн хөрөг нэвтрүүлгүүд хэл найруулга, хэлбэр агуулга, ур хийцийн хувьд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Хөрөг баатрынхаа түүхийг өгүүлэхдээ тухайн нийгэм цаг үеийн түүхийг хамтатган харуулж чаддагаараа сэтгүүлч Г.Золжаргалын бүтээлүүд ихэд онцгой. Мөн аж амьдралын бодит дүр зураг, аливаа түүхийг үзүүлэхдээ элдэв маяг оруулалгүй, уянгалж нуршилгүйгээр энгийн, ойлгомжтой, товч тайлбарлаж бичдэг нь түүний онцлог. Тиймдээ ч телевизийн салбарт Г.Золжаргалын бүтээлүүд чансаа дээгүүрт орж байна. “Zoljargal&Son film”-ийн бүтээсэн “Шастин эмчийн сувилагч” 2009 он, “Мандолинаас Бетховены 11

симфони хүртэл” 2009 он, “Оюун” 2010 он, “Ардын Цэрэндулам” 2010 он, “Лодойдамба ба битлз хэй жүүд” 2013 он, “Өвгөн зураачийн өчил” 2015 он, “Тэр жилийн хүүхдүүд” 2011 он, “Өвөлжих хун залуу уран бүтээлчид Анхны алхам” 2016 он, “Мажигаа багш” 2011 он, “Алсрах тусам тодорно” 2018 он, “Амарбатын нэг өдөр” 2005 он, “Бодлын дайны өрөг” 2012 он, “Айл гэрийн амьдрал” 2013 он, Хан Хэнтийн баавай 2016 он, “Ардын зохиолч Ч.Ойдов” 2017 он, “Абай” 2018 он гэх мэт олон арван хөрөг нэвтрүүлгүүд нь шинэ залуу уран бүтээлчдэд сургалтын чухал материал болохыг энд тэмдэглэе.

**Э**цэст нь дүгнэхэд хөрөг нэвтрүүлэг нь хувь хүн, нийгмийн бодит амьдрал, цаг үеийн үйл явдал дээр үндэслэн бүтээгдэхийн хувьд түүхэн баримт болж үлддэг, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлдэг, танин мэдэхүйн болон хүмүүжлийн өндөр ач холбогдолтой, үнэ цэнтэй, телевизийн онцгой бүтээл юм. Тиймээс телевизийн редакцууд нийтлэл нэвтрүүлгээ чанаржуулах, уран бүтээлчдийнхээ ур чадварыг нэмэгдүүлэх, цаашлаад чанартай бүтээл хийхэд нь цаг хугацаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тал дээр онцгойлон анхаарах шаардлагатай байна. Нөгөөтээгүүр телевизийн хөрөг нэвтрүүлгийн төрлөөр ажиллах сонирхолтой сэтгүүлчдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, сэтгүүлч бэлтгэдэг их дээд сургуулиудын хөтөлбөрт энэ чиглэлийн практик хичээлийг, онолын хичээлтэй хослуулан оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

#### Эшлэл

1. Банзрагч М. Сэтгүүлчийн хөдөлмөр. УБ., 2006, х.75.



2. Наранжаргал Х. Телевизийн сэтгүүл зүй. Үндсэн ойлголт, зөвлөмж.УБ., 2006, х.66.
3. Батжаргал Д. Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар. УБ., 2008, х.89.
4. Мелвин Менчер. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс (Орч. Б.Агар нар).УБ., 2001, х.249.
5. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2018, х.313.
6. Банзрагч М. Сэтгүүлчийн хөдөлмөр. УБ., 2006, х.76.
7. Зулькафиль М.Сэтгүүл зүйн тайлбар толь.УБ., 2018, х.313.
6. Наранжаргал Х. Телевизийн сэтгүүл зүй. Үндсэн ойлголт, зөвлөмж. УБ., 2006.
7. Стандартные масштабы кадров [http://editlw.ru/articles.php?article\\_id=42](http://editlw.ru/articles.php?article_id=42)

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Батжаргал Д. Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар. УБ., 2008.
2. Банзрагч М. Сэтгүүлчийн хөдөлмөр. УБ., 2006.
3. Дожоодорж Д нар. Зурагт зулын хойморт заларсан нь /дуртгал, тэмдэглэл, нийтлэл/.УБ.,1997.
4. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 2018.
5. Мелвин Менчер. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс (Орч. Б.Агар нар).УБ., 2001.

#### **Summary**

This article discusses the skills of Mongolian television journalists and video makers on portrait programs. Portrait, a major independent genre of journalism, was originally published in newspapers and magazines, but today they have evolved into television and radio broadcasts, reaching audiences not only with words but also with sounds and videos. In this way, portrait is being adopted in all genres of television without any difference. Examples include portrait articles, portrait interviews, portrait movies, portrait reporting, portrait news, and portraiture. However, in these genres, portraits often lose their original quality and are neutralized. In fact, there are only a very few television productions with a format that can fully define a television portrait program. The research aims to empirically study the genre, format, changes and some issues of portraiture skills on 4 portrait programs.